УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
213400, Увс аймаг, Улаангом сум,
Ө.Бадрахын гудамж
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,
E-mail: uvs@audit.gov.mn

2019.02.18 № УВА-2019/146/СТА-ТШЗ
танай______________-ны №________________-т

УВС АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ СТАТИСТИКИЙН ХЭЛТСИЙН ДАРГА П.ТУНГАЛАГ ТАНАА

**Аудитын гэрчилгээ**

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Увс аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтсийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Увс аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтсийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Увс аймаг дахь Төрийн аудитын газар аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Увс аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтсийн 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

030054

**Үүрэг, хариуцлага**

Увс аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтэс нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь Увс аймаг дахь Төрийн аудитын газрын үүрэг юм.

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР М.БАТСУУРЬ

## Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт |
| АДБОУС | Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт |
| АОУС | Аудитын олон улсын стандарт |

## Агуулга

1 Аудитын гэрчилгээ ....................

2 Аудитын тайлан .................... 3

2.1 Оршил .................... 3

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .................... 3

2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .................... 4

2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин .................... 4

2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ .................... 5

2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .................... 5

2.7 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар .................... 5

2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн .................... 6

2.8.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал....................

2.9 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал . 6

2.10 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга .................... 6

2.11 Шилэн дансны мэдээлэл .................... 6

2.12 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга .................... 6

2.13 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл .................... 6

3 Аудит хийсэн санхүүгийн тайлан ....................

3.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ....................

3.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ....................

3.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан ....................

3.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

3.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ....................

# 1 Аудитын тайлан

## 1.1 Оршил

Увс аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтсийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг хэлтсийн дарга П.Тунгалаг танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

## 1.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Увс аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтсийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Увс аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтсийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Увс аймаг дахь Төрийн аудитын газрын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 01 дүгээр сарын 25-аас 2019 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 02 дугаар сарын 18-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Увс аймаг дахь Төрийн аудитын газрын гэрээт аудитор Ц.Магнайдүүрэн хариуцаж хэрэгжүүлэв.

Увс аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтсийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2019 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн 04 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

## 1.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

## 1.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Увс аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтсийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго: Санхүүгийн хяналт шалгалтын үр дүнг сайжруулж гарсан зөрчил, дутагдлыг арилгахад зөвлөмж, Монгол Улсын Статистикийн тухай болон бусад хууль тогтоомжийг удирдлага болгон статистикийн талаархи аймгийн Засаг даргын бүрэн эрхийг нутаг дэвсгэрийн хэмжээнд хэрэгжүүлэх, хараат бус байж эдийн засаг, нийгэм, хүн амзүйн талаархи шинжлэх ухааны арга зүйгээр тооцсон, статистикийн үнэн бодит мэдээлэл, судалгаагаар төр, засаг, иргэн байгууллагад адил тэгш үйлчлэх чиглэл өгч хариуцлага тооцож ажиллана.

Увс аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтсийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

- Засгийн газрын тогтоолоор ажилтнуудын цалин хөлс нэмэгдсэн

## 1.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Увс аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтсийн санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Acolous” програм хангамж ашигладаг байна.

Увс аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтсийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

## 1.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Увс аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтсийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 4 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 4 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

## 1.7 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлын 1 хувиар сонгов.

Төсөвт байгууллагын хувьд нийт зардлаар материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгох нь зохимжтой гэж үзлээ.

Увс аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтсийн 2018 оны нийт зардал 166841,5 мянган төгрөг бөгөөд түүний 1 хувь болох 1668,4 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 1 хувиар тооцох нь зохимжтой гэж үзлээ.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

### 1.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 4 чиглэлээр аудитын 4 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд алдаа, зөрчилд илрээгүй болно.

### 1.9 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

2018 оны санхүүгийн тайлангийн аудитаар анхаарал татахуйц асуудал гараагүй болно.

### 1.10 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Увс аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтэс чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой 2018 онд 75957.4 мянган төгрөгийн төсөв батлагджээ.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 75957.4 мянган төгрөг буюу 100 хувьтай байгаа ба 7.7 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

### 1.11 Шилэн дансны мэдээлэл

Увс аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтсийн Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг 2018 оны 3-р улирлын байдлаар нийцлийн аудит хийхэд итгэл үзүүлсэн байна.

### 1.12 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан байна.

### 1.13 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Увс аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтсийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Увс аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтсийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн тул "Зөрчилгүй" санал дүгнэлт өгч байна.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР /М.БАТСУУРЬ/

АУДИТЫН МЕНЕЖЕР /М.БАТ-АМГАЛАН/

БЭЛТГЭСЭН: ГЭРЭЭТ АУДИТОР /Ц.МАГНАЙДҮҮРЭН/

2019 оны 02 сарын 18-ны өдөр

АУДИТЫН ТАЙЛАНТАЙ ТАНИЛЦСАН

ДАРГА /П.ТУНГАЛАГ/

НЯГТЛАН БОДОГЧ /Н.ДУЛАМЖАВ/

ОЮА0042 9064613
8516129102

СТ-1А

# САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **5,691,575.54** | **5,937,475.54** |
| **33** | **АВЛАГА** | 00.00 | 48,000.00 |
| **335** | **Бусад авлага** | 00.00 | 48,000.00 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 00.00 | 48,000.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 5,569,575.54 | 5,889,475.54 |
| **354** | **Хангамжийн материал** | 5,569,575.54 | 5,889,475.54 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 70,500.00 | 84,500.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 2,618,976.10 | 2,924,876.10 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 2,880,099.44 | 2,880,099.44 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **8,124,723.56** | **2,500,387.24** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 8,124,723.56 | 2,500,387.24 |
| **392** | **Биет хөрөнгө** | 8,124,723.56 | 2,500,387.24 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 40,893,336.00 | 32,712,636.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -37,712,941.05 | -32,712,636.00 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 40,865,806.54 | 31,518,999.31 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -36,581,727.75 | -29,466,612.01 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 6,983,011.55 | 5,653,334.90 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -6,322,761.73 | -5,205,334.96 |
| 39301 | Програм хангамж | 450,000.00 | 450,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -450,000.00 | -450,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **13,816,299.10** | **8,437,862.78** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **138,085.00** | **30,600.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 138,085.00 | 30,600.00 |
| **413** | **Өглөг** | 138,085.00 | 30,600.00 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | | |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | | |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **13,678,214.10** | **8,407,262.78** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 13,678,214.10 | 8,407,262.78 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 13,678,214.10 | 8,407,262.78 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 13,678,214.10 | 13,678,214.10 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | -5,270,951.32 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **13,816,299.10** | **8,437,862.78** |

СТ-2А

# САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (І)** | **91,495,574.67** | **161,570,527.00** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **91,044,908.00** | **161,570,527.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 42,176,900.00 | 75,957,400.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 42,176,900.00 | 75,957,400.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 48,868,008.00 | 85,613,127.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 999,000.00 | 5,584,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 36,644,408.00 | 80,029,127.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **92,659,125.72** | **166,841,478.32** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **92,659,125.72** | **166,841,478.32** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 91,660,125.72 | 166,329,496.32 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 41,681,686.00 | 82,884,732.00 |
| 210101 | Үндсэн цалин | 21,368,261.00 | 40,786,135.00 |
| 210102 | Нэмэгдэл | 5,573,500.00 | 12,569,557.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 1,258,000.00 | 2,515,200.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 13,481,925.00 | 27,013,840.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 4,180,871.00 | 9,633,884.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 2,700,529.00 | 6,455,847.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 370,086.00 | 794,581.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 296,066.00 | 635,375.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 74,018.00 | 158,917.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 740,172.00 | 1,589,164.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 11,150,199.02 | 28,419,253.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,000,450.00 | 4,171,170.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 9,576,567.02 | 22,992,816.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 535,862.00 | 697,967.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 37,320.00 | 557,300.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 99,780.00 | 509,500.00 |
| 210604 | Урсгал засвар | 99,780.00 | 509,500.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 13,490,000.00 | 12,212,500.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 13,490,000.00 | 12,212,500.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 16,825,075.00 | 26,865,291.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 16,539,525.00 | 26,279,491.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 56,000.00 | 224,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 00.00 | 210,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 118,800.00 | 118,800.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 00.00 | 33,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 4,232,514.70 | 5,804,336.32 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 00.00 | 180,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 4,232,514.70 | 5,624,336.32 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 999,000.00 | 511,982.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 999,000.00 | 504,199.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 999,000.00 | 504,199.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 00.00 | 7,783.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 00.00 | 7,783.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **-1,163,551.05** | **-5,270,951.32** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **-1,163,551.05** | **-5,270,951.32** |

CT-2A

## МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Төгрөгөөр/

8517144095
ОЮА0055 9065555

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **93,138,197.80** | **163,071,707.00** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **91,044,908.00** | **163,071,707.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 42,176,900.00 | 75,957,400.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 42,176,900.00 | 75,957,400.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 48,868,008.00 | 85,613,127.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 999,000.00 | 5,584,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 36,644,408.00 | 80,029,127.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 00.00 | 1,501,180.00 |
| 134001 | Нийгмийн даатгалын сангаас санхүүжих | 00.00 | 1,501,180.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **89,991,456.80** | **163,071,707.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **89,991,456.80** | **163,071,707.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **88,992,456.80** | **161,034,744.00** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 40,906,825.00 | 82,399,455.00 |
| 210101 | Үндсэн цалин | 20,593,400.00 | 40,275,143.00 |
| 210102 | Нэмэгдэл | 5,573,500.00 | 12,569,557.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 1,258,000.00 | 2,515,200.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 13,481,925.00 | 27,039,555.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 4,500,085.00 | 10,147,145.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 2,863,691.00 | 6,764,763.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 409,100.00 | 845,595.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 327,277.00 | 676,537.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 81,821.00 | 169,059.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 818,196.00 | 1,691,191.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 10,464,232.00 | 25,779,253.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 346,980.00 | 1,712,070.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 9,558,232.00 | 22,992,816.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 451,200.00 | 697,967.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 107,820.00 | 376,400.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 48,000.00 | 509,500.00 |
| 210604 | Урсгал засвар | 48,000.00 | 509,500.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 13,374,000.00 | 12,268,200.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 13,374,000.00 | 12,268,200.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 17,333,825.00 | 29,152,691.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 16,539,525.00 | 26,279,491.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 56,000.00 | 150,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 00.00 | 210,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 118,800.00 | 118,800.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 00.00 | 33,000.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 619,500.00 | 2,361,400.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 2,365,489.80 | 778,500.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 272,200.00 | 778,500.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **999,000.00** | **2,036,963.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 999,000.00 | 2,029,180.00 |
| 213202 | Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж | 00.00 | 1,501,180.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 999,000.00 | 528,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 00.00 | 7,783.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 00.00 | 7,783.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 2,365,489.80 | 778,500.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 272,200.00 | 778,500.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **999,000.00** | **2,036,963.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 999,000.00 | 2,029,180.00 |
| 213202 | Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж | 00.00 | 1,501,180.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 999,000.00 | 528,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 00.00 | 7,783.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 00.00 | 7,783.00 |

CT-4A

## ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|
| C01 | **2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **00.00** | **00.00** | **00.00** | **00.00** | 00.00 |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C08 | **2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **00.00** | **00.00** | **00.00** | **00.00** | 00.00 |
| D01 | **2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **00.00** | **00.00** | **13,678,214.10** | **00.00** | 13,678,214.10 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **00.00** | **00.00** | **13,678,214.10** | **00.00** | 13,678,214.10 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | -5,270,951.32 | 00.00 | -5,270,951.32 |
| D09 | **2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **00.00** | **00.00** | **8,407,262.78** | **00.00** | 8,407,262.78 |

ТГ

# ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Өмнөх оны | | Тайлант оны | |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төловлогоо | Гүйцэтгэл | Батлагдсан төловлогоо | Гүйцэтгэл |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 00.00 | 00.00 | 75,957,400.00 | 75,949,617.00 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 00.00 | 00.00 | 75,957,400.00 | 75,949,617.00 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 00.00 | 00.00 | 75,429,400.00 | 75,421,617.00 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 00.00 | 00.00 | 60,879,900.00 | 60,879,900.00 |
| 210101 | Үндсэн цалин | 00.00 | 00.00 | 40,412,700.00 | 40,275,143.00 |
| 210102 | Нэмэгдэл | 00.00 | 00.00 | 12,432,000.00 | 12,569,557.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 00.00 | 00.00 | 2,515,200.00 | 2,515,200.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 00.00 | 00.00 | 5,520,000.00 | 5,520,000.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлох шимтгэл** | 00.00 | 00.00 | 7,305,600.00 | 7,305,600.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 00.00 | 00.00 | 4,870,400.00 | 4,870,400.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 00.00 | 00.00 | 608,800.00 | 608,800.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 00.00 | 00.00 | 487,100.00 | 487,100.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 00.00 | 00.00 | 121,700.00 | 121,700.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 00.00 | 00.00 | 1,217,600.00 | 1,217,600.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 00.00 | 00.00 | 2,717,100.00 | 2,716,717.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 00.00 | 00.00 | 452,900.00 | 1,386,970.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 00.00 | 00.00 | 795,200.00 | 676,370.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 00.00 | 00.00 | 835,400.00 | 276,977.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 00.00 | 00.00 | 633,600.00 | 376,400.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 00.00 | 00.00 | 509,500.00 | 509,500.00 |
| 210604 | Урсгал засвар | 00.00 | 00.00 | 509,500.00 | 509,500.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 00.00 | 00.00 | 772,200.00 | 772,200.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 00.00 | 00.00 | 772,200.00 | 772,200.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 00.00 | 00.00 | 2,700,600.00 | 2,693,200.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 00.00 | 00.00 | 150,000.00 | 150,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 00.00 | 00.00 | 210,000.00 | 210,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 00.00 | 00.00 | 118,800.00 | 118,800.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 00.00 | 00.00 | 39,600.00 | 33,000.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 00.00 | 00.00 | 2,182,200.00 | 2,181,400.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 0.00 | 0.00 | 544500.00 | 544500.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 00.00 | 00.00 | 544,500.00 | 544,500.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 0.00 | 0.00 | 528000.00 | 528000.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 00.00 | 00.00 | 528,000.00 | 528,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 00.00 | 00.00 | 528,000.00 | 528,000.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 00.00 | 00.00 | 75,957,400.00 | 75,949,617.00 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 00.00 | 00.00 | 75,957,400.00 | 75,949,617.00 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 00.00 | 00.00 | 75,957,400.00 | 75,949,617.00 |
| 132007 | Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих | | | | |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **00.00** | **00.00** | **09.00** | **09.00** |
| 650001 | Төрийн захиргааны албан хаагч (ТЗ) | 00.00 | 00.00 | 05.00 | 05.00 |
| 650010 | Гэрээт ажилтан | 00.00 | 00.00 | 04.00 | 04.00 |